



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/92

Хужирт сум

Онцгой байдлын ажиллагааны
удирдлагын төв байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн “Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай” 06 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/320 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулах “Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургууль оролцох Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, гүйцэтгэх үүргийг 2 дугаар, Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүтэцийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Стратегийн команд штабын сургууль оролцох бэлтгэл ажлыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл), Эрэн хайх, аврах бүлгийн дарга, дэслэгч (Б.Баярсайхан), бэлэн байдлыг хангаж оролцохыг сумын Онцгой комиссын гишүүд, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд тус тус үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622301183
D:Alban bichig,Zahiramj 2023